



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар A/123

Шивээговь сум

Төрийн албан хаагчийн орчин нөхцлийг  
 сайжруулах арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлыг  
 хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авч буй “Төрийн албан хаагчийн орчин нөхцлийг сайжруулах арга хэмжээ”-ний хүрээнд хийгдсэн ажлыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

М.Гантуяа

(Хууль эрх зүйн асуудал хариуцсан  
 мэргэжилтэн)

Гишүүд:

Л.Цэнд-Аюуш

(Нягтлан бодогч)

Б.Баярцэцэг

(Нярав)

П.Ганжаргал

(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг  
 төлөвлөлт, худалдан авах ажиллагаа  
 хариуцсан мэргэжилтэн)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авч буй “Төрийн албан хаагчийн орчин нөхцлийг сайжруулах арга хэмжээ”-ний хүрээнд хийгдсэн ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион

байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг комиссын дарга (М.Гантуяа)-д, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Б.Алтансүх)-д, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, үр ашгийг дээшлүүлэн ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА